

**ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ, ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ АЖИЛЛУУЛАХ  
ТАЛААР НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН  
ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТ**

2017 оны 12 дугаар сарын 25

Зорилт	№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин / тоо хэмжээ, хувь/	Хүрсэн түвшин / хэрэгжилтийн хувь, тоо хэмжээ/	Зарцуулсан хөрөнгө түвшин /Хэрэгжилтийн хувь, тоо хэмжээ/	Тайлбар
1. Хүний нөөцийг чадавхжуулах	1	Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан гадаад, дотоодын сургалт	Дотоод сургалтын тоо	5-аас дээш	Дээд газраас 2017 онд зохион байгуулсан сургалтуудад Төрийн албаны тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох журмын тухай нийт 15 удаагийн сургалтуудад 30 гаруй байгууллагын нэгжийн менежер, ажилтан, албан хаагчид тогтмол хамрагдаж мэдээлэл авч ажилласан. • БСШУС-ын яамнаас 2017 оны 11 дүгээр сарын 26-30-ны өдрүүдэд Соёл, урлагийн ажилтны II чуулганы хүрээнд зохион байгуулагдсан сургалт, семинарт хамрагдсан. • Дээд газраас Архив, албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдол хариуцсан харъяа байгууллагуудын ажилтан албан хаагчдад зориулсан сургалтуудад тогтмол хамрагдаж,		
		Мэргэшсэн туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх мэргэшсэн боловсон хүчний үзүүлэлт	Албан хаагчдын хамрагдсан байдал	80 хувиас дээш			
			Гадаад сургалтад албан хаагчдын хамрагдсан байдал боловсон хүчний мэргэшсэн үзүүлэлт	20 хувиас дээш			

				<p>НСУГ-ын харьяа байгууллагуудын архив, бичиг хэргийн ажилтан, албан хаагчдад 1 удаагийн нэгдсэн сургалтыг зохион байгуулсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Тус газраас санаачлан “Сувд партнерс” ХХНөхөрлөлтэй хамтран “Зохиогчийн эрх, түүнд хамаарах эрхийн тухай хууль”-ийн талаар зөвлөгөө мэдээлэл өгөх цуврал лекц, сургалтуудыг 500 орчим СУИС-ийн оюутан, багш нарыг хамруулсан 2017 оны 02 дугаар сарын 22-оос 05 дугаар сарын 03-ны өдрийг хүртэл нийт 10 удаагийн сургалтыг зохион байгуулсан. “Угийн бичиг хөтлөх аргазүй” сургалтыг 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр “Улаанбаатар Чуулга”-ын номын санд нийслэлийн 9 дүүргийн Соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн, Соёлын ордны менежерүүдийн дунд зохион байгуулсан. Сургалтыг “Монгол толбо” нийгэмлэгтэй хамтран зохион байгуулж, онол, дадлага гэсэн 2 хэсгээс бүрдсэн 11 бүлэг хичээл дагуу угийн бичиглэл, зураглал дадлага ажлыг хийлгэн, ном гарын авлага тарааж, мэргэжилтнүүдэд сертификат олгосон.</li> <li>• Соёл, урлагийн салбарт ажиллагчдын мэргэжил дээшлүүлэх чиглэлээр: Тус газрын харьяа байгууллага болох Улаанбаатар хотын нийтийн төв номын сангаас алслагдсан дүүрэг болох БНД, БХД, НД, СХД-ийн Жаргалант тосгоны</li> </ul>		
--	--	--	--	--	--	--

				<p>Соёлын ордны номын сангуудын номын санчдад номын сангийн мэдээлэл, лавлагаа, каталоги, иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг гаргах арга зүйн сургалтыг зохион байгуулсан. Мөн Улаанбаатар хотын төв номын сангийн мэргэжил арга зүйн зөвлөлөөс 2017 онд алслагдсан дүүргүүдийн соёлын ордны номын сангийн номын санчдад зориулан мэргэжлийн болон ажлын байрны сургалтыг нийтдээ 6 удаа зохион байгуулж ажилласан. Хараагүй хүмүүсийн мэдээлэл харилцааны технологийн сургалт, (DAISY) цахим ном бүтээх сургалт, хэвлэмэл номыг сканнер ашиглаж цахим болгох, компьютерийн анхан шатны бичих чадвар олгох сургалтуудыг тус тус зохион байгуулж нийт 8 ажилтан ,албан хаагчид хамрагдсан. Чингэлтэй дүүрэг дэх салбар номын санчдад номзүйн цахим програмын талаар зөвлөгөө, сургалтыг 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулж 3 номын санч, 3 оюутанг хамруулсан. Төрийн захиргааны менежментийн мэргэшүүлэх сургалтад хамруулахаар тус газраас саналыг Удирдлагын академид 2017 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр явуулсан. Нэг албан хаагчийг мэргэшүүлэх сургалтын элсэлтийн шалгалтад оролцуулсан боловч тэнцээгүй болно. Мөн 2017 оны 12 дугаар</p>		
--	--	--	--	---	--	--

					сарын 21-ны өдөр Улаанбаатар хотын нийтийн номын сангийн сургалтын танхимд “Хүний нөөц, Архив, албан хэрэг хөтлөлт” арга зүйн сургалтад харьяа соёлын байгууллагуудын хүний нөөц, архив, бичиг хэргийн нийт 22 ажилтан, албан хаагчдыг хамруулсан.		
Хэсгийн дундаж:					100%		
2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах	3	Цалин хөлс, шагнал урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	Шагнал, урамшуулал д хамрагдсан албан хаагчдын тоо	Гүйцэтгэл ээр	Тус газар нь соёл, урлагийн салбарт олон жил идэвхи санаачлага, үр бүтээлтэй хөдөлмөрлөж, соёл, урлагийг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд уран бүтээл, авьяас билгээ зориулан амжилт гаргасан нийт 62 уран бүтээлчид, ажилтан албан хаагчид, ахмадуудын материалыг шагналд дэмжин уламжилж ажиллалаа. Үүнээс Ерөнхийлөгчийн нэрэмжит шагналд 1, БСШУСЯ-ны шагналд 32, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд 13, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар / Нийслэлийн Засаг даргын шагналд 16 хүний материалыг дэвшүүлснээс “Найрамдалт одон”-оор 1, БСШУСЯ-ны “Соёлын тэргүүний ажилтан” цол тэмдэг 6, “Жуух бичиг”-ээр 9, “Монгол Улсын Соёлын Гавьяат Зүтгэлтэн” цол тэмдгээр 1, Нийслэлийн тэргүүний ажилтан 2, НЗД-ын “Жуух бичиг”-ээр 3, Нийслэлийн “Хүндэт тэмдэг”-ээр 2 хүн тус тус шагнагдсан байна. Мөн Нийслэлийн Соёл, урлагийн газрын		
			Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан олгох нэмэгдэл, зэрэг дэв, шатлал ахиулах	Гүйцэтгэл ээр			

					<p>“Өргөмжлөл”-өөр 12 байгууллага, иргэнийг шагнаж урамшуулсан. Байгууллагын ажилтан, албан хаагчдын үр дүнгийн гэрээ болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр тогтмол дүгнэж, гүйцэтгэлийн үр дүнг үнэлж, 2 албан хаагчийг шагнаж урамшуулан, 2 албан хаагчийг дээд шатны байгууллагын шагналд дэмжин тодорхойлж, 1 албан хаагчийн зэрэг дэвийн нэмэгдлийг ахиулж, нийт албан хаагчдад үрд дүнгийн гэрээний мөнгөн урамшуулалыг жилийн эцсийн байдлаар олгоод байна.</p>		
4	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байдал	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулга	Сэтгэл ханамж 80 хувиас дээш	<p>Ажлын байрны орчин нөхцлийг сайжруулах чиглэлээр албан хаагчдын өрөө тасалгааны өнгө үзэмжийг сайжруулан урсгал засвар хийж, хүйтэн сэрүүний нөхцөлд цонх хаалганы дулаан алдалтаас сэргийлэн засвар үйлчилгээг хийж ажилласан. Мөн ажлын байрны эргэн тойрны зам тайлбайн мөсөн бүрхүүлийг цэвэрлэж иргэд халтирч унаж бэртэхээс урьдчилан сэргийлэн ажилласан. Амьсгалын замын томуу, томуу төст өвчлөлтэй холбоотой ажилтан, албан хаагчдыг эрүүл аюулгүй, цэвэр орчин нөхцөлд албан үүргийг гүйцэтгүүлэх зорилт тавьж өрөө тасалгааг цэцэгжүүлэн, чийгтэй цэвэрлэгээг өдөр бүр тогтмол хийлгэж байна. Мөн хүйтэн сэрүүн улиралд ханиад томуу туссан албан хаагчдад чөлөө олгон тархалт,</p>			

					дэгдэлтээс урьдчилан сэргийлэн ажиллаж байна. Нийт ажилтан албан хаагчдын сэтгэл ханамж 90%-тай ажиллаж байна.		
	5		Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлэх	Гүйцэтгэлээр	2017 онд төсөв хэмнэхтэй холбоотой албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлж чадаагүй болно.		
	6.	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг	Жилд 1-ээс доошгүй удаа	<p>Тус газар нь ажилчин, албан хаагчдын эрүүл мэнд, чөлөөт цаг, ажил амралтыг үр ашигтай зарцуулах, хамт олны уур амьсгалыг зөв бүрдүүлэх зорилготой соёл, урлагийн харьяа байгууллагуудын дунд спорт өдөрлөгийг жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг. Энэ жил 2017 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Багахангай дүүрэгт зохион байгуулсан. Өдөрлөгт харьяа Соёл, урлагийн 11 байгууллагын 300 гаруй албан хаагчид оролцож гар бөмбөг, алсын зайн шидэлт, олс таталт гэсэн спортын 3 төрлөөр өрсөлдсөн.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Иргэдийн эрүүл, орчинд амьдрах эрхийг хангах талаар авах зарим арга хэмжээний талаарх ажлын хүрээнд байгууллагын нийт эмэгтэй албан хаагчдыг “Golden gem” бялдаржуулах төвийн иогийн дасгалд 2017 онд хамруулсан. Жил бүрийн 3-4 дүгээр сард уламжлал болгон харьяа соёлын байгууллагуудын дунд спорт</li> </ul>		

				өдөрлөгийг зохион байгуулан ажилллаж байна.		
		Албан хаагчдын хамрагдалт	100хувь	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, хэрэгжүүлэгч агентлагуудын ажилтан албан хаагчдын нэгдсэн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг 2017 оны 02 дугаар сарын 13-ны өдөр төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгт зохион байгуулагдаж тус газрын нийт 14 ажилтан, албан хаагчид хуваарийн дагуу эмнэлэгийн үзлэгт хамрагдлаа. Байгууллагад төсөв эрүүл мэндийн хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлийн төсөв байхгүй улмаас албан хаагчдыг хамруулах боломжгүй байсан.		
		Хэсгийн дундаж:			<b>80%</b>	
Нийт :					<b>90%</b>	

ХЯНАСАН:  
СОЁЛЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

М.МӨНХСАЙХАН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:  
ХҮНИЙ НӨӨЦ, ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН

Б.МӨНГӨНТҮЛХҮҮР